

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2025 оны эхний хагас жил/**

2025 оны 07 дугаар сарын 09

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, биелэлтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөх, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан зорилго, зорилт, арга хэмжээг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2025 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 11 зорилгын 37 зорилтын 137 арга хэмжээний эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг дараах байдлаар үнэлэв. Үүнд:

- ЗОРИЛГО 1. “Боловсруулах аж үйлдвэрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2028 онд 4.9 хувьд хүргэнэ” гэсэн зорилгын хүрээнд 3 зорилт 16 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **79.4 хувь**;
- ЗОРИЛГО 2. “Эрдэс баялгийн салбарын (геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энерги) салбарын хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах” гэсэн зорилгын хүрээнд 6 зорилт 20 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт – **97.1 хувь**;
- ЗОРИЛГО 3. “АХ-4.2.1, 4.2.24, ШСБ-3.1, 3.2, 3.1.2, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.3.1.1, 3.3.1.2, 3.3.1.2, 3.3.1.10, 3.3.1.11, УХЖТ-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН 1.2.2.1, 1.2.2.8, 1.2.2.9, 1.2.2.10, УХЖТ-ИЙН 1.4.1, геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 1 зорилт 7 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **64.3 хувь**;
- ЗОРИЛГО 4. “ах-4.2.1, 4.2.24, шсб-3.1, 3.2, 3.1.2, мухтжүч-4.2.1, згүах-3.3.1.1, 3.3.1.2, 3.3.1.2, 3.3.1.10, 3.3.1.11, ухжт-ийн тэргүүлэх чиглэлийн 1.2.2.1, 1.2.2.8, 1.2.2.9, 1.2.2.10, ухжт-ийн 1.4.1, дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 1 зорилт 2 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **100 хувь**;

- ЗОРИЛГО 5. “АХ-4.2.14, 4.2.15, 4.2.16, ШСБ-3.2, МУХТЖҮЧ-4.2.1, 4.2.11, ЗГҮАХ-3.3.1.1, 1.3.5.2, 3.3.1.2, 3.3.1.6, 3.3.1.10, УХЖТ-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН 1.2.2.4, 1.2.2.5, 1.2.2.6 УХЖТ-ИЙН 1.4.3, боловсруулах хүнд үйлдвэрийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 3 зорилт 17 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **63.3 хувь**;
- ЗОРИЛГО 6. “Эрдэс баялаг (геологи, цөмийн энерги, уул уурхай, газрын тос)-ийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулахад нэгдсэн удирдлагаар хангах” гэсэн зорилгын хүрээнд 8 зорилт 20 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **92.1 хувь**;
- ЗОРИЛГО 7. “Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 3 зорилт 13 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **97.3 хувь**;
- ЗОРИЛГО 8. “Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ” гэсэн зорилгын хүрээнд 1 зорилт 8 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **100 хувь**.
- ЗОРИЛГО 9. “Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, эрх зүйн зөвлөгөө, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын мэдээллийн технологийг хөгжүүлэх” гэсэн зорилгын хүрээнд 6 зорилт 26 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **98.8 хувь**.
- ЗОРИЛГО 10. “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичигт салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гаргах, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана” гэсэн зорилгын хүрээнд 2 зорилт 3 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **100 хувь**.
- ЗОРИЛГО 11. “Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу эрсдэлд суурилсан хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулна” гэсэн зорилгын хүрээнд 1 зорилт 5 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **83.3 хувь**.

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ
/2025 оны эхний хагас жил/

Зорилго	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Үнэлгээ /%/				ДУНДАЖ ДҮН %/
			35%-аас дээш	70-85%	0-70%	Х/Б	
I. БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД ЭЗЛЭХ ХУВИЙГ 2028 ОНД 4.9 ХУВЬД ХҮРГЭНЭ.	3	16	11	1	4	-	79.4
II. ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН (ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ЦӨМИЙН ЭНЕРГИ) САЛБАРЫН ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ,	6	20	13	5	-	2	91.7

БОДЛОГЫН НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ.							
III. АХ-4.2.1, 4.2.24, ШСБ-3.1, 3.2, 3.1.2, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.3.1.1, 3.3.1.2, 3.3.1.2, 3.3.1.10, 3.3.1.11, УХЖТ-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН 1.2.2.1, 1.2.2.8, 1.2.2.9, 1.2.2.10, УХЖТ-ИЙН 1.4.1, ГЕОЛОГИЙН СУДАЛГАА, ЭРЭЛ, ХАЙГУУЛЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭН, ШИНЭ ОРД ГАЗРУУДЫГ НЭЭЖ, ГАЗРЫН ХЭВЛИЙН НЭГДСЭН ГЕОМЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛНЭ.	1	7	2	5	-	-	64.3
IV. АХ-4.2.1, 4.2.24, ШСБ-3.1, 3.2, 3.1.2, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.3.1.1, 3.3.1.2, 3.3.1.2, 3.3.1.10, 3.3.1.11, УХЖТ-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН 1.2.2.1, 1.2.2.8, 1.2.2.9, 1.2.2.10, УХЖТ-ИЙН 1.4.1, ДОРНОГОВЬ АЙМАГТ ДОТООДЫН ТҮҮХИЙ ЭДЭД ТҮШИГЛЭСЭН ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛЖ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН АВТО БЕНЗИН, ТҮЛШНИЙ ТОДОРХОЙ ХУВИЙГ ДОТООДООСОО ХАНГАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.	1	2	2	-	-	-	100
V. АХ-4.2.14, 4.2.15, 4.2.16, ШСБ-3.2, МУХТЖҮЧ-4.2.1, 4.2.11, ЗГҮАХ-3.3.1.1, 1.3.5.2, 3.3.1.2, 3.3.1.6, 3.3.1.10, УХЖТ-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН 1.2.2.4, 1.2.2.5, 1.2.2.6 УХЖТ-ИЙН 1.4.3, БОЛОВСРУУЛАХ ХҮНД ҮЙЛДВЭРИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.	3	17	5	-	9	2	63.3
VI. ЭРДЭС БАЯЛАГ (ГЕОЛОГИ, ЦӨМИЙН ЭНЕРГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС)-ИЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХАД НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ.	8	20	16	-	3	1	92.1
VII. ДОРНОГОВЬ АЙМАГТ ДОТООДЫН ТҮҮХИЙ ЭДЭД ТҮШИГЛЭСЭН ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛЖ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН АВТО БЕНЗИН, ТҮЛШНИЙ ТОДОРХОЙ ХУВИЙГ ДОТООДООСОО ХАНГАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.	3	13	10	1	-	2	97.3
VIII. АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ТУСГАЙ	1	8	8	-	-	-	100

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ ЭСЭХ АСУУДЛЫГ ИЛ ТОД, ХӨНГӨН ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭНЭ.							
IX. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, САЛБАРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ.	6	26	24	1	-	1	98.8
X. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТОСЛ, ШИЙДВЭР, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ САЛБАРЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ ГАРГАХ, ДОТООД АУДИТ ХИЙЖ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАЖ АЖИЛЛАНА.	2	3	3	-	-	-	100
XI. АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ, УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛНА.	1	5	2	-	1	2	83.3
НИЙТ	37	137	96	13	19	10	88.2

Дөрөв. Дүгнэлт.

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг Төрийн захиргааны удирдлагын газраас нэгтгэн ирүүлсэн бөгөөд тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **88.2 хувийн** гүйцэтгэлтэй байна гэж дүгнэлээ.
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 11 зорилгын 37 зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн нийт 137 арга хэмжээнээс 96 арга хэмжээ 85-аас дээш буюу бүрэн хангалттай, 13 арга хэмжээ 70-85 хүртэл буюу хангалттай, 19 арга хэмжээ 70 хүртэл буюу хангалтгүй, 10 арга хэмжээ хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй байна.

Тав. Зөвлөмж.

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт удаашралттай, гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго, зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсөл хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүнг оновчтой байдлаар тайлагнах, холбогдох баримт нотолгоог тухай бүр цуглуулж тайланд хавсаргах /холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр, тайлан хүлээн авсан тухай баримт, судалгааны тайланд хяналт тавьсан тухай баримт, санхүүгийн баримт болон албан бичгийн огноо г.м.:/;
3. Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа тайлангийн чанар, утга найруулгыг хянах, тогтсон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх.

ХЯНАСАН:


ХШҮДАГ-ЫН ДАРГА



Б.ӨНӨМӨНХ

ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ТАНИЛЦУУЛГА БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАГ-ЫН ШИНЖЭЭЧ



Ц.ТЭМҮҮЖИН